

ДЭЛХИЙН ЦЭРЭГ УЛС ТӨРИЙН БАЙДАЛ МОНГОЛ УЛС БОЛОН УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД НӨЛӨӨЛӨХ НЬ

А.Ажилчин

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга. Дэлхий дахины халуун цэгүүдэд өрнөж буй цэрэг, улс төрийн үйл ажиллагаануудыг сонирхон судалж, тэдгээр цэрэг дайны болон улс төр, эдийн засгийн байдлууд Монгол Улсын аюулгүй байдал түүний дотор хилийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж болохыг судлаачийн зүгээс судалсан болно.

Түлхүүр үг. Аюулгүй байдал, дайн, цэрэг улс төр, хил хамгаалалт.

Оршил

Дэлхий дахин даяаршин өөрчлөгдөж байгаа өнөө үед дэлхий дахин, бүс нутагт болж буй нөхцөл байдлыг нарийн мэдэж, түүнд урьдчилан дүгнэлт хийж, аливаа үүсэж болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхийн тулд зайлшгүй дэлхийн цэрэг, улс төрийн байдлыг судлах шаардлагатай юм.

“Улс төрийг чи сонирхохгүй бол Улс төр өөрөө чамайг сонирхох болно” гэдэг нийгмийн хууль байдгийг эргэн саная.

Өнөөдрийн байдлаар дэлхий дахины анхаарлын төвд байгаа хэд хэдэн халуун цэгүүд болох Орос-Украины дайн, Израйл-Ливаны сөргөлдөөн, Өмөнд солонгос-Хойд солонгосын харилцаа, Хятад-Тайвайн, Хятад-Шинжааны асуудлууд, цөмийн зэвсгийн тэмцэл, том гүрнүүдийн улс төрийн сонгуульт ажлууд зэрэг үйл явдлууд өрнөсөөр байна. Монгол Улсад

аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох сонгуульт ажлууд явагдаж, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч төрийн дээд айлчлал хийсэн ба энэ нь дэлхийн улс орнуудын анхаарлын төвд багагүй өртлөө.

Монгол Улс хэдийгээр дайнгүй хэдий ч аюулгүй байдлаа нэн тэргүүнд тавих нь зүйтэй ба Монгол Улсын Үндсэн хуульд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно¹. гэж заасан.

Тэгвэл өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчин, дайны бүхий үед зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд орж үүрэг гүйцэтгэх хилийн цэргийн зэвсэг, инженер, техник, технологи, бие бүрэлдэхүүний ур чадвар, цалин,

¹ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.

хангамж зэрэгт анхаарах цаг нэгэнт болжээ гэдгийг мөн ямар ч шалтгаан гарган, дайныг эхлүүлж болдог юм байна гэдгийг Орос-Украины дайнаас харж болох юм.

Өөрийн илтгэлдээ Олон Улсын цэрэг, улс төрийн олон нөхцөл байдал дундаас Орос-Украины дайны асуудлыг сонгон авч, Монгол Улс болон хилийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж болох юм вэ гэдгийг судлахыг зорьсон.

Нэг.Оросын Холбооны Улс болон Украины даны эхлэх болсон шалтгаан:

Орос-Украины дайн нь Орос, Украины хооронд 2014 оны 2 сараас хойш үргэлжилж байгаа дайн юм. 2013-2014 оны туршид үргэлжилсэн

Украины Евромайдан эсэргүүцлийн хөдөлгөөний төгсгөлд болсон Майдан хувьсгалаар Украины ерөнхийлөгч болон засгийн газрыг огцруулжээ. Энэ үйл явдлыг залгуулаад Орос Крымыг эзэлж өөртөө нэгтгэсэн бөгөөд Украины Оростой хил залгаа Донбас дахь салан тусгаарлах үзэлтнүүдэд цэрэг зэвсгийн дэмжлэг үзүүлж эхэлсэн. 2014 оноос 8 жилийн туршид ийнхүү хэд хэдэн сөргөлдөөн гарч улс төрийн хувьд хурцадмал байдалтай байсан ба 2021 оноос Украины хил дагуу Оросын цэрэг зэвсгийн бөөгнөрөл үүсэж, 2022 оны 2 сарын 24-нөөс Оросын зэвсэгт хүчин Украин руу довтолсон.

Украины ерөнхийлөгч Виктор Янукович 2014 оны 2 сарын 22-нд огцрохоосоо өмнө "Европын Холбоо-

Украины хоорондын холбооны гэрээ"-нээс татгалзаж, Оросын Евразийн эдийн засгийн холбоотой хамтарч ажиллах шийдвэр гаргаснаар Украины зүүн, өмнөд хэсгүүдэд Оросыг дэмжсэн үймээн гарч эхэлсэн ба үүний зэрэгцээ аливаа цэргийн тэмдэглэгээгүй Оросын цэргүүд Крымын хойг руу нэвтэрч, стратегийн ач холбогдолтой байршил, дэд бүтцийн объект, засгийн газрын барилгуудыг мэдэлдээ авчсан. 2014 оны 3 сарын 16-нд Крымыг Оростой нэгтгэх зорилгоор тус мужид санал асуулгыг маргаантайгаар явуулж хоёр өдрийн дараа Оростой нэгтгэжээ. 2014 оны 4 сард Бүгд Найрамдах Донецк Ард Улс (Донецкт), Бүгд Найрамдах Луганск Ард Улсыг (Луганскт) зүүн Украин дахь салан тусгаарлах үзэлтнүүд Оросын улс төрч, цэргийн дэмжлэгтэйгээр байгуулж салан тусгаарласнаа мэдэгджээ. 2014 оны 8 сард Оросын талаас тэмдэглэгээгүй цэргийн автомашинууд Украины талд буюу Донбасст нэвтэрч оржээ. Оросын талаас оролцоог үгүйсгэсэн ч Донбасс дахь дайнд Орос цэргүүд оролцож, цэрэг зэвсгийн нөөц бэлтгэж байсныг илрүүлсэн.

Дайныг зогсоох зорилгоор 2015 оны 2 сард эхлүүлсэн Минскийн гэрээнд Орос, Украины талаас гарын үсэг зурсан ч хэд хэдэн маргааны улмаас зааврууд нь бүрэн хэрэгжээгүй. Дайн зогсонги байдалтай байсаар 2019 оны 7 сар гэхэд Украины нутаг дэвсгэрийн 7 хувийг эзэлсэн гэж Украины засгийн газраас мэдээлж байсан юм. 2022 оны 9 сар гэхэд Украины 18 хувийг Орос эзэлсэн.

2021 оны эхэнд болон 2021 оны сүүлээс 2022 оны 2 сар хүртэл Оросын тал Украинтай хил ойролцоо өөрийн болон Беларусын нутаг дэвсгэрт цэрэг зэвсгийн бөөгнөрөл үүсгэж, НАТО гэх мэт ажиглагчдын анхаарал шүүмжлэлд өртжээ. Энэ үеэр Оросын ерөнхийлөгч Владимир Путин НАТО-гийн өргөжилтийг шүүмжилж, Украиныг гишүүнээ болгохыг хориглох шаардлага тавьж, Украиныг хуурамч улс ба Оросын салшгүй хэсэг хэмээх үзлийг илэрхийлж байжээ. 2022 оны 2 сарын 21-нд Оросын тал Донецк, Луганск дахь салан тусгаар улсуудыг хүлээн зөвшөөрч, цэргээ явуулсан ба үүнээс 3 хоногийн дараа "Цэргийн тусгай ажиллагаа" нэрийдлээр Украиныг эзлэхээр довтолсон юм.

Дайныг олон улсаас ялангуяа барууны орнууд шүүмжилсэн бөгөөд Украинд цэрэг зэвсэг, тусламж явуулахаас гадна Орос, Беларусыг эдийн засгийн санкцын арга хэмжээг авч эхэлсэн.

Хоёр. Орос-Украины дайны өнөөгийн байдал.

Оросын Холбооны Улс 2025 онд зэвсэгт хүчин дээ 145 тэрбум доллар зарцуулахаар улсынхаа төсөвт тусгасан гэтэл нийгмийн халамждаа 70 тэрбум доллар төсөвлөсөн бөгөөд энэ мөнгөнөөс амь үрэгдсэн цэргийн нөхөн төлбөр, шархадсан цэргүүдийн эмчилгээний эмчилгээний зардал зэрэгт тал хувь нь зарцуулагдах тооцоо байгаа бөгөөд үндсэн дээ Оросын Холбооны Улсын төсвийн 4/3 хувь нь дайнд зарцуулагдахаар байна.

Харин Украины хувьд Барууны орнууд тэр дундаа Америкийн Нэгдсэн Улс, НАТО-гийн дэмжлэгээр дайнд оролцож байгаа бөгөөд дунджаар 50 тэрбум доллар зарцуулахаар тооцоолон энэ мөнгийг Оросын Холбооны Улс гадаад дахь валютаас авахаар шийдвэр гараад байгаа юм.

Тэгвэл дайнд нөлөөлж байгаа хоёр том хүчин зүйл байгаа нэгдүгээрт тухайн улсын эдийн засаг, хоёрдугаарт техник, технологи, зэвсэг, логистикийн асуудлууд гэж үзэж байгаач хоёр дахь асуудал нь эргээд эдийн засгийн асуудлууд дагуулдаг юм. Иймээс ч Оросын Холбооны Улс болон барууны орнууд НАТО-д Украинд үзүүлж буй тусламж дэмжлэгээ зогсоовол бид дайныг зогсоох болон гэсэн шаардлага тавьж байгаа билээ.

Тэгвэл бусад улс орнуудыг зэвсэгт хүчиндээ ямар хэмжээний мөнгө зарцуулж байгаа авч үзвэл бидний урд хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улс 224 тэрбум доллар буюу дайнтай байгаа Оросын Холбооны Улсаас их хэмжээний мөнгө төсөвлөсөн, хоёр Солонгос мэдээж байнгын дайны бэлэн байдалд байж цэрэг аримдаа томоохон төсөв төсөвлөдөг нь тодорхой юм, Япон улс ирэх онд зэвсэгт хүчиндээ 60 тэрбум доллар төсөвлөсөн гэх мэтчилэн аваад үзвэл Улсын аюулгүй байдал гэдэг нь цэрэг аримдаа хэр их хэмжээний мөнгө зарцуулж байгаагаас шууд хамаардаг болох нь ойлгогдож байна.

Олон улсууд бусад улсын дэмжлэг тусалцаанд найдахаас илүүтэйгээр өөрийн зэвсэгт хүчиндээ

найдах нь зөв юм байна гэдгийг ойлгож, зэвсгээр хөөцөлдөж эхлээд байгаа ба илүү зэвсэг, техниктэй мэргэжлийн аримтай байхыг чухалчлаад эхэлсэн. Энэ нь Нэгдсэн үндэсний байгууллага төдийлөн хөндлөнгөөс оролцож асуудлыг шийдвэрлэх чадамжгүй юм гэдгийг Орос-Украины дайн буюу нэгдсэн үндэсний байгууллагын гишүүн хоёр орон байлдаж байгаагаар харж болох юм. Монгол Улс ч нэгдсэн үндэсний байгууллагын гишүүн орон ба хэрэв дайн болбол биднийг хамгаалан гэдэг буруу ташаа ойлголтоос салах ёстой болж таарч байна. Харин нэгдсэн үндэсний байгууллагаас илүүтэйгээр цэргийн эвсэл холбоод идэвхжиж байгааг НАТО-гийн жишээ нь дээр харж байна. Мөн Азид шинэ НАТО үүсгэх асуудлыг Японы ерөнхий сайд идэвхтэй ярьж байна. Хэрэв азид шинэ НАТО үүсвэл бидний урьд хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улс зайлшгүй зөрчилд орох юм.

Хорин нэгдүгээр зуун бол энэрэл хайр, энх амгалангийн зуун, шинжлэх ухаан технологийн зуун, аз жаргалын зуун болно гэж байсан ч үгүй юм байна. Орос Украины дайн гараад бүтэн хоёр жил гаруй хугацаа өнгөрсөн. Олон ч хүн үрэгдсэн, тэр хирээр байшин, дэд бүтэц устаж сөнөөгдлөө. Хоёр талаасаа энэ дайнд нэг сая шахам цэрэг алагдаж, шархадсан гэж үзэж байгаа. Энэ дайн бол сүүлийн 80 жилд европт гарч байгаагүй аймшигт цуст дайн болоод байгаа юм. Энэ дайнд хүн олноор үхээд зогсохгүй, эдийн засагт маш их хохирол учруулж байна. Орос, Украин

хоёр дэлхийд үр тариа нийлүүлэлтээрээ дээгүүр байрт ордог. Энэ дайн эхлэнгүүт үр тариа нийлүүлэлт зогсож африкийн орнуудад өлсгөлөн нүүрлэж эхэлсэн юм. Хүнсний барааны үнэ болон нефть шатахууны үнэ өсөөд эхэлсэн. Украин, Орос улсын хүн амын өсөлт эрс буурсан зэрэг статистик судалгаа гарсан.

Энэ дайн хоёр орны хүн амын өсөлтөд маш муугаар нөлөөлж байна. Украин 46 сая хүн амтай байсан бол 10 сая хүн ам нь Польш болон бусад өрнөдийн орон руу дүрвэж явсан. Украин улс олон мянган цэрэг, иргэдээ энэ дайнд алдаад байна. Орос улс 146 сая хүн амтай боловч 800 000 орос иргэн гадаад руу дүрвэж жил ирэх тутам дүрвэгчдийн тоо нэмэгдэж байна. Орост олон зуун мянган эрчүүд цэрэгт татагдаж фронтод тулалдаж байна. Орост төрөлт 15.0 хувиар буурч, 2023 онд төрсөн хүүхдийн тоо 1999 оны түвшинд доошилжээ. Орост 1999 онд нэг эмэгтэйд 1 хүүхэд төрсөн буюу нийт 1.2 сая хүүхэд төрж байсан бөгөөд хүүхэд төрүүлэх насны эмэгтэйчүүдийн тоо 1999-2023 оны хооронд буюу 24 жилийн турш тавны нэгээр буурчээ. Оросын Буриад болон Дагестаны залуус энэ дайнд олноор амь үрэгдэж байгаа тул эдгээр жижигхэн бүгд найрамдах улсуудын хүн ам эрс хорогдож байна. Нэг жишээ татахад Оросын Буриад улсын буриад монголчуудын тоо 120 жилийн өмнө хаант Оросын үед 250 000 байсан бол одоо энэ тоо яг хэвээрээ огт өсөөгүй байна. Орос улсын цэргийн тоо үлэмж их хорогдож байгаа тул шоронд

хоригдож байгаа олон гэмт хэрэгтнүүдийг суллаж дайнд явуулсан.

НҮБ Оросын цэрэг Украинд халдсан эхний өдрөөс эхэлж одоо хүртэл дайныг зогсоож цэргээ Украины газар нутгаас гаргахыг удаа дараа шаардсан олон тогтоолыг гаргасан боловч Орос улс огт биелүүлэхгүй өдий хүрчээ. Оросын цэрэг Украины олон хотын дэд бүтэц, орон сууц, цахилгаан, дулааны станцууд, усан хангамжийг бөмбөгдөн сүйтгэж олон зуун тэрбум долларын хохирол учруулаад байна. НҮБ Украинд учруулсан дайны хохирлыг төлөх тухай тогтоол гаргасан боловч Орос улс огт биелүүлсэнгүй. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд Их Британи, АНУ, Орос, БНХАУ, Франц гэсэн 5 орон байнгын гишүүнээр ажилладаг. Гэтэл НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн Орос улс энх тайвныг хангах үүрэгтэй мөртлөө дайн хийж бусад орныг түрэмгийлээд байхад НҮБ яаж ч чадахгүй байна. НҮБ-ын дүрмийг шинэчилж дайн өдөөсөн, бусад орныг түрэмгийлсэн улсыг НҮБ-ын Зөвлөлийн байнгын гишүүнээс хасах, цаашлаад НҮБ-ын гишүүнээс нь хасах болон Аюулгүйн Зөвлөлийн даргыг сар бүр өөрчлөх бус, ядаж нэг жилийн хугацаанд өөрчлөхгүй байх зэрэг нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай байгаа талаар яригдаж эхэлсэн. Дайн хийж буй хоёр тал хоёулаа буулт хийж байж дайны галыг зогсоож болох юм. Гэтэл хоёр тал хоёулаа дайныг ялалтад хүртэл нь үргэлжлүүлнэ гэсэн тул дайныг зогсоох арга мухардаж байгаа билээ. Энэ дайнаас болж дэлхийн ихэнх улсууд

ялангуяа Оростой хиллэдэг улсууд аюулгүй байдлаа хангахад анхаарч цэргийн зардлаа эрс нэмэгдүүлжээ. Дэлхийн улсууд 2024 оны цэргийн зардлаа 2 их наяд ам долларт хүргэжээ.

Гурав: Монгол Улс болон улсын хил хамгаалалтад нөлөөлөх нь.

Дээр дурдсанчлан Монгол Улс нэгдсэн үндэсний байгууллагын гишүүн орон ба хэрэв дайн болбол биднийг хамгаалан гэдэг ойлголт худлаа болж байгаа юм. Ямар ч оронтой ямар ч шалтаг шалтгаан үүсгэн дайныг эхлүүлж болж байгаа харах ёстой. Монгол Улс дэлхийн 2 том гүрний дунд оршин байдаг ба энэ хоёрыг давж хэн ч орж ирж бидэнтэй байлдахгүй гэж ойлгож байлаа. Гэтэл мөнхийн хөрш хоёр улстайгаа мөнхийн эв найрамдалтай байж чадах эсэх нь бас л эргэлзээ дагуулж байгааг санах ёстой юм.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улс дэлхийн анхаарлын төвд зүй ёсоор орсон. Энэ нь дайныг өдөөсөн хэргээр буруутгагдаад байгаа Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путинг олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улс баривчлах ёстой талаар олон улсын байгууллага, зурагт, радио, сонин, сэтгүүлээр нийтэлж Монгол Улсад ч зарим нэг албан бичиг, шаардлагууд ирсэн юм. Үүний зэрэгцээ тухайн айлчлалын үеэр дайныг эсэргүүцэгч Монгол Улсын хэсэг иргэд тэр дундаа соёл урлагийн салбарт танигдсан Төрийн соёрхолт, Монгол

Улсын гавьяат жүжигчин Д.Сосорбарам тэргүүтэй хэсэг бүлэг хүмүүс жагсаал, цуглаан хийж, уриа лоозон барьж жагсан эсэргүүцлээ илэрхийлсэн юм. Мөн Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путинг баривчлаагүй тохиолдолд Монгол Улсад ямар арга хэмжээ авах талаар ч яригдаж байлаа. Энэ бүгдээс харахад Монгол Улс дайнаас хол байна гэж ойлгож болохгүй юм. Ялангуяа эдийн засгийн хувьд сайнгүй манай оронд барууны орны эдийн засгийн хориг арга хэмжээ хүндээр нөлөөлж болохыг анхаарах нь зүйтэй.

Дайнтай холбоотой Монгол Улс руу дүрвэх, цагаачлах Орос, Тува, Буриад, Алтайсик зэрэг иргэд ихсэх хандлагатай байгааг мөн Монгол Улсад байгаа Хятад, Вьетнам иргэдийн тоо зэрийг харгалзан хүн ам цөөн Монгол Улс зайлшгүй энэ асуудалд анхаарал хандуулах шаардлага тулгарч байгаа ба хүүхэд залуучуудын дунд эх орон ч үзлийг төлөвшүүлэх нь бас нэг нэн тэргүүний асуудал болж байгаа билээ. Гадаад иргэдтэй гэр бүл болж байгаа иргэдийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар

тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.¹ гэж заасныг дахин сануулъя.

Оросын Холбооны Улс дайны үер цэргийн алба хаах насны иргэдийг гадаад улсууд руу зорчуулахгүй байгаа ба зарим үед цэргийн албанд дайчилж байгаа бөгөөд дайныг эсэргүүцсэн, цэргийн алба хаах сонирхолгүй иргэд нэн ялангуяа бага ястнууд буюу Тува, Алтайсик, Буриад зэрэг иргэд дүрвэж, эсвэл зэвсэглэсэн хэсэг бүлэг цэргүүд дайны талбараас оргож зэвсэгтэйгээр Монгол Улсын хилийг нэвтрэх асуудал үүсэж болзошгүй юм. Аливаа дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, тулгаралтын үед хамгийн эхэнд хилчид тэдэнтэй нүүр тулж хариу арга хэмжээ авдаг тул эхний ээлжид хилийн цэргийн техник, технологи, зэр зэвсэг, зарцуулах эдийн засаг, санхүүгийн асуудлыг байж болох хамгийн дээд хэмжээнд хүргэж, бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр төр засгаас дорвитой арга хэмжээг шийдэхтэйгээр авч хэрэгжүүлэх цаг нэгэнт болсон гэдгийг судлаачийн хувиас үзэж байна.

Зөвхөн хойд хил буюу Оросын Холбооны Улстай хиллэдэг хэсгээр ч биш Өмнөд хил буюу Бүгд найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг хэсэгт ч

¹ Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.

мөн адил асуудлууд байгаа юм. Бүгд найрамдах Хятад Ард Улс Шинжаан Уйгарт явуулж буй бодлог нь маш хатуу чанга, харгис хэрцгий байгаа бөгөөд үүнийг эсэргүүцсэн хэнийг ч Улс төрийн дахин боловсрол олгох төвд аваачиж сургалт явуулдаг гэж мэдээлж байгаа хэдий ч үнэн хэрэгтээ тэр нь маш хатуу харгис шорон юм. Мөн Өвөр Монголын өөртөө засах оронд хэл соёлын дарамт шахалт асар их явуулж сүүлдээ Монгол хил бичгээр сургалт явуулахыг хориглосон. Энэ бүгдийг эсэргүүцсэн, залхсан, эрх чөлөөг хүссэн Өвөр Монгол, Уйгар, Казак зэрэг иргэд дүрвэж Монгол Улсын хилийг зөрчиж болзошгүй юм. Үүнтэй мөн л хилчид хамгийн эхэнд нүүр тулж бослого, үймээн гаргагч этгээдүүдийн эсрэг хариу арга хэмжээ авах юм.

Дүгнэлт.

Даяаршин өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд бие биеэсээ асар их хамааралтай болсон гэдгийг ойлгож байгаа ч дэлхийн улс орнууд өөрийгөө хамгаалах цэрэг арми түүнд зарцуулах эдийн засагтаа асар их ач холбогдол өгч байгаа харгалзан Монгол Улс ч энэ тал дээр анхаарлаа хандуулан зэвсэгт хүчин, хилийн цэрэгтээ төсвийн тодорхой хувийг зарцуулах нь зүйтэй юм. Одоогийн байдлаар урсгал зардал, цалин хөлснөөс өөр бодитой тусгаж

хэрэгжүүлсэн төсөв хөрөнгө нэн ховор билээ.

“Эх орондоо хамгийн үнэтэй залуу насаа өгдгийг нь бодоод хилчдийг хүндлэх хэрэгтэй” хэмээн И.В.Сталин нэг цагт хэлжээ. Гэтэл өнөөдрийн байдлаар төрийн тусгай алба хаагчдын цалин хөлсний хэмжээнд хийсэн судалгаагаар хамгийн бага цалинтай бусад ижил төстэй байгууллагуудын алба хаагчдаас ялгарах нэмэгдэл тун ховор, тэтгэвэрт гараад орох оронгүй, хүүхдүүд нь эцэг эхээ дагаж олон сургууль дамждаг улмаар сурлаг нь мууддаг, эрүүл мэнд, нийгмийн халамжийг төдийлөн сайн хүртэж чадахгүй байгаа зэрэг нь судлаач миний хувьд нэн харамсалтай санагдаж байгаагаа нэгтгэн дүгнэлээ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1.Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992.

2.Үндэсний аюулгүй байдлын тухай хууль.УБ., 2001.

3.Монгол улсын хилийн тухай хууль. УБ., 2016.

4.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.

5.Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966.

6.Дашаваа Д, Ганболд Ц, Муратхан А. Хилийн аюулгүй байдал. УБ., 2021.